

СОЛОНГОСЫН ХОЙГИЙН ЦӨМИЙН ХЯМРАЛ: МОНГОЛ УЛСЫН БАЙР СУУРЬ

С.Батсайхан¹

***Abstract:** From 1990-th year when North Korea started development of the nuclear program nuclear crisis on the Korean Peninsula began. 1993, 2003 in connection with the announcement of North Korea of an exit from NPT and the aggravation of a situation of the Korean Peninsula is called as the first, second North Korean nuclear crisis. At the head of the USA, other countries to refuse North Korea from development of the nuclear program carried out multilateral works by negotiations, sanctions, and strong-arm tactics, but wished success didn't achieve. North Korea not only didn't refuse the nuclear program but 2006, 2009, 2013 carried out nuclear test. In this regard North Korea nuclear crisis began to influence to safety of North East Asia, including the interests of Mongolia. From this point of view Mongolia with the advent of North Korean nuclear crisis began to pay attention, made considerable efforts settlement of this question. Mongolia became on the party of the diplomatic solution of this question and carried out active work as providing mutual understanding of the relevant parties. 1992 Mongolia declared the country a denuclearized zone, in the country organized bilateral meetings of six-party talks, put forward an initiative "UB of a meeting and negotiations", and to make the contributions in the solution of NK of nuclear crisis.*

***Key words:** Korean Peninsula nuclear crisis: position of Mongolia*

1. БНАСАУ цөмийн зэвсэгтэй болох урьдчилсан нөхцөл

Солонгосын хойгийг цөмийн зэвсэглэлээр хөөцөлдөхөд хүргэсэн гол шалтгаан бол Солонгос үндэстнийг 2 хэсэгт хуваасан 1950-1953

1. МУИС-ийн ОУХС-ийн докторант

оны Солонгосын дайн байв. Гал зогсоох түр гэрээ байгуулж, эвлэрсэн тэр үеэс солонгосын хоёр тал хоёулаа цөмийн салбарыг сонирхож эхэлжээ. БНАСАУ анх 1959 онд ЗХУ-тай цөмийн эрчим хүчний салбарт хамтарч ажиллах тухай Хэлэлцээр байгуулж, улмаар 1964 онд БНАСАУ-ын Ёнбин-д ЗХУ-ын тусламжтай цөмийн шинжилгээний төв байгуулжээ. Харин 1985 оны 12-р сард БНАСАУ ЗХУ-ын шахалтаар ОУАЭА (IAEA) –ийн Цөмийн Зэвсэг Үл Дэлгэрүүлэх Гэрээ (NPT)–нд нэгдэн оржээ. БНАСАУ 1986 оны 6 сард солонгосын хойгийг цөмийн зэвсэггүй бүс нутаг болгох талаар санаачлага гаргаж “үйлдвэрлэхгүй, туршихгүй, хадгалахгүй, нутаг дэвсгэр дээгүүрээ цөмийн зэвсэг тээвэрлүүлэхгүй, мөн гадаадын цөмийн зэвсгийг нутаг дэвсгэр, агаарын болон далайн орон зайдаа тээвэрлүүлэхгүй байх” зарчмыг дэвшүүлж, АНУ-ыг Өмнөд Солонгосоос цөмийн цэргийн техник хэрэгслээ гаргахыг шаардаж байв.² Ийнхүү 1980-аад оны дунд үе хүртэл Умард Солонгос-ын цөмийн салбар ЗХУ-тай байгуулсан гэрээний хүрээнд, хатуу хяналтан дор ерөнхийдөө эрчим хүчний чиглэлтэй явж ирсэн гэж үзэж болохоор бол харин 20-р зууны сүүл үеэс цэргийн чиглэлтэй болж ирсэн байна. Энэ нь олон улсын харилцааны системд гарсан өөрчлөлттэй холбоотой.

1980-аад оны сүүлчээр дэлхийн социалист систем нурах үйл явц өрнөжээ. Тухайлбал: 1990 оны 9 сард зүүн, баруун Герман нэгдэх гэрээнд гарын үсэг зурж, ОХУ бүрэн эрхт байдлаа тунхаглаж, 1991 оны 4 сард Варшавын гэрээ хүчингүй болж, 1991 онд ЗХУ +оршин тогнохоо больсноор ЗХУ-ын зээл тУмард Солонгосламж, хамгаалал нэгэнт үгүй болжээ. Социалист ихэнх орон ардчилал, зах зээлийн системд нэгдэх зам руу оров. БНХАУ зэрэг цөөн хэдэн улс социалист үзэл баримтлалаа авч үлдсэн ч зах зээлийн эдийн засгийн харилцаанд бас шилжив. Харин Умард Солонгос дэглэмээ хадгалж үлдэхийн тулд нийгэм, эдийн засгийн харилцаандаа өөрчлөлт оруулахаас татгалзсан цорын ганц улс болсон нь тУмард Солонгос улсын гадаад дотоод нөхцөл байдлыг нэн хүндрүүлсэн ажээ. ТУмард Солонгос улс гадаад талдаа ганцаардмал, хаагдмал улс болж, дотооддоо эдийн засгийн хямралд оржээ. БНАСАУ нийгэм-улс төр, эдийн засгийн хөгжлийн шинэ арга

2. Корейский полуостров: метаморфозы послевоенной истории. 2008. Торкунов.А.В., Денисов.в., Ли Владимир, стр.424

зам эрэлхийлэхэд хүрсэн байна. Үүссэн нөхцөл байдлаас гарах нэг арга замыг тУмард Солонгос улс үндэсний батлан хамгаалах бодлого хэмээн үзэж, түүний хүрээнд цөмийн зэвсгээр шаргуу хөөцөлдөж эхэлсэн гэж үзэх үндэстэй. 1992 онд батлагдсан БНАСАУ-ын шинэ Үндсэн Хуулин-д Үндэсний Батлан хамгаалах Бодлого онцгой байр суурь эзэлж тУмард Солонгосгай бүлэг болж,³ өмнө нь Ардын Төв Хорооны бүрэлдэхүүнд байсан Батлан Хамгаалах Зөвлөл гэдэг төрийн шинэ байгууллагыг цэргийн удирдлагын Төрийн дээд байгууллага(өмнө нь ерөнхийлөгчийн эрх үүрэгт хамаарч байсан) хэмээн эрх үүргийг нь тогтоожээ.⁴

Солонгосын хойгийн цөмийн анхдугаар хямрал

Анх 80-аад оны эхээр АНУ Умард Солонгосын Ёнбин дахь цөмийн төхөөрөмжийг илрүүлж, 1989 онд Франц улс хиймэл дагуулаар түүнийг нь бататгажээ.⁵ Ийнхүү 1990-ээд оны эхэн үеэс Умард Солонгос цөмийн зэвсэг боловсруулж байж болзошгүй гэж үзсэнээс эхлэн тУмард Солонгос улсыг ОУАЭА (IAEA)-ийн 1991 оны 9 сард баталсан цөмийн аюулгүй байдлын хэлэлцээрийн тогтоолыг хүлээн зөвшөөрч, гарын үсэг зурахыг шаардах болсон. Харин Умард Солонгос-ын тал “АНУ Өмнөд Солонгост байрлуулсан цөмийн зэвсгээ гаргаагүй тохиолдолд тогтоолд нэгдэх боломжгүй” гэсэн байр суурийг илэрхийлж байв.

Харин мөн оны сүүлээр АНУ ЦЗҮДТГ (NPT)-ийн гишүүн ямар ч орны эсрэг цөмийн зэвсэг хэрэглэхгүй гэсэн тУмард Солонгосгай мэдэгдэл хийж,⁶ Өмнөд Солонгосоос цөмийн зэвсгээ гаргах болсноор хэд хэдэн нааштай алхмууд хийгджээ. Тухайлбал: 1991 оны 12 сард Пхеньян ба Сөүл найрамдал, харилцан үл довтлох, хамтран ажиллах болон Солонгосын хойгийн цөмийн зэвсэггүй статУмард Солонгосын Тунхаглалын гэрээнд гарын үсэг зуралцаж, улмаар 1992 оны 1 сарын 30-нд БНАСАУ ОУАЭА (IAEA)-тай цөмийн аюулгүй байдлын хэлэлцээрт гарын үсэг зурж, ОУАЭА (IAEA)-тай гэрээ байгуулж, цөмийн объектондоо шалгалт оруулахыг зөвшөөрч, үүний хариуд

3. БНАСАУ-ын Үндсэн хууль. 1992, IY бүлэг 56-61

4. БНАСАУ-ын Үндсэн хууль. 1992, YI.3.111-116

5. Б.Лхагваа. Нэгдсэн Солонгос айсуу. Стратегийн судалгааны хүрээлэн. 2015. Тал.132

6. Володин Д. А. США и Северная Корея: от Буша-старшего к Бушу-младшему // США-Канада: экономика, политика, культура. 2003, № 3. с. 37

Сөүл, Вашингтоны зүгээс “Тим спирт 92” цэргийн сургуулилтын ажиллагаагаа зогсоох зэрэг тохиролцоонд хүрчээ. Гэвч Умард Солонгосын цөмийн объектуудыг шалгах явцад тУмард Солонгос улсын гаргасан үзүүлэлт болон шалгалтын үр дүнгийн хооронд ихээхэн зөрөө гарсан, цөмийн объектоос холгүй орших хоёр объектоо шалгуулахаас татгалзсан зэрэг үндэслэлүүдээр 1993 оны 2-р сарын 11-нд ОУАЭА-ийн захирал Х.Бликс БНАСАУ-д “тУмард Солонгосгай шалгалт” явуулахыг санал болгосон ба АНУ, БНСУ-ын зүгээс тУмард Солонгос улсын цөмийн хаягдлын газар болон цэргийн 2 объект дээр тУмард Солонгосгай шалгалт оруулахыг шаарджээ. Харин Умард Солонгос уг шаардлагыг хүлээж авахаас тагалзав. Хариуд нь АНУ 1993 оны 3 сард солонгосын хойгийн өмнөд талд “Тим спирт” цэргийн сургуулилтаа дахин явуулж, Өмнөд Солонгос дахь цэргээ хоёр шаттай гаргах ажиллагаагаа зогсоожээ. Умард Солонгосын удирдлага үүнийг “улсын аюулгүй байдал, бүрэн эрхт байдалд” заналхийлсэн явдал гэж үзээд, 1993 оны 3 сарын 12-нд тУмард Солонгос улс Цөмийн Зэвсэг Үл Дэлгэрүүлэх Тухай Гэрээнээс (NPT) гарахаа мэдэгджээ. Үүний тайлбар болгож 1993 оны 3 сарын 12-нд хуралдсан БНАСАУ-ын Ардын Төв Хорооны Хурлын 9 дэх удаагийн 7-р бүгд хурлаас “Улсынхаа хамгийн дээд эрх ашгийг хамгаалахын тулд аргагүйн эрхэнд ЦЗҮДТГ (NPT)-ээс гарахаар болсон”⁷ хэмээн мэдэгдэл хийсэн билээ. Ингэснээр солонгосын хойгийн цөмийн нэгдүгээр хямрал үүсчээ. АНУ тэргүүтэй барууны улс орнууд Умард Солонгос-ын энэ үйлдлийг олон улсын энх тайванд заналхийлсэн үйлдэл хэмээн буруушааж, хариу арга хэмжээ авахаар бэлтгэв. АНУ цөмийн объект байрлах Енбин-д цохилт өгч болзошгүй гэж үзсэн Умард Солонгос-ын удирдлага цохилт өгсөн тохиолдолд ӨС-т хариу цохилт хийнэ хэмээн мэдэгдэхээр барахгүй БНАСАУ, БНХАУ-ын холбоотны гэрээ хүчин төгөлдөр байгаа тул Хятад улс оролцоно гэсэн байр суурийг хүртэл илэрхийлж байв.⁸

АНУ Умард Солонгос-ын цөмийн объект-д цохилт өгөх нь хэт эрсдэлтэй гэж үзсэн тул тУмард Солонгос улсыг хаах (blockade), үүний тулд НҮБ-ын АЗ-д эдийн засгийн хатуу хориг арга хэмжээний тогтоолыг өргөн барихаар болов. Гэвч үр нөлөөтэй хориг арга хэмжээ

7. 북한외 외교정책과 대외관계. 김계동. Умард Солонгосын гадаад бодлого ба гадаад харилцаа. Ким Гиз Дун. 2012. тал 142.

8. Мөн тэнд. тал.145

авахад хамгийн нөлөөтэй БНХАУ Умард Солонгосын эсрэг хэт хатуу хориг арга хэмжээ хэмээн эсэргүүцэж, чингэсэн тохиолдолд НҮБ-ын АЗ-д үүнтэй холбоотой хориг тавих эрхээ /veto/ хэрэгжүүлнэ гэснээр тогтоол-ыг зөөлрүүлэхэд хүргэжээ. Хятадын Ерөнхий сайд Ли Пен “энэ асуудлаарх шахалт нэмэгдвэл солонгосын хойгийн байдлыг хүндрүүлээд зогсохгүй хямралыг улам нэмэгдүүлнэ” гэж мэдэгдсэн байна.⁹

Ийнхүү АНУ-ын Умард Солонгос-ыг “ташуурдах” хүчний бодлого төдийлөн үр дүнд хүрээгүй ба оронд нь БНХАУ-ын зуучлал дор харилцан буулт хийсэн яриа хэлэлцээ явагдаж эхэлсэн ч 1994 оны эхээр явуулсан ОУАЭА-ын шалгалтаар Умард Солонгос-ын цөмийн түлш боловруулах цогцолборт өмнө нь тавигдсан лацыг авч хаясан байсан зэрэг шалтгаанаас дахин хурцадмал байдал үүсч, АНУ солонгосын хойгт цэргийн оролцоогоо нэмэгдүүлэх хэд хэдэн алхам хийж, хурцадмал байдал даамжрах аюултай байдалд хүрсэн үед АНУ-ын ерөнхийлөгч асан Жимми Картер 1994 оны 6 сард Пхеньян-д Ким Ир Сентэй уулзаж, хэлэлцээний үр дүнд Женев-т АНУ ба БНАСАУ-ын хооронд тохиролцооны ерөнхий дүр зургыг гаргаж чадсан гэж үнэлэгддэг Умард Солонгос-АНУ-ын хооронд Суурь хэлэцээр (framework agreement) байгуулагджээ. Энэ Суурь хэлэлцээр юун түрүүнд Умард Солонгос одоо ба ирээдүйд цөмийн зэвсгээр хөөцөлдөхгүй байхын тулд “цөмийн ба ердийн эрчим хүчээр хангах тухай баталгаанд гарын үсэг зурж, ө.х. РБМК (реактор большой мощности канальный) төрлийн бүх төрлийн тоног төхөөрөмжийг царцааж, бүр мөсөн Умард Солонгостгахаар” болж, энэхүү үйл ажиллагааг Умард Солонгос ОУАЭА-ын хяналтан дор хэрэгжүүлэхээр болжээ. Хариуд нь АНУ-ын тал Умард Солонгост 2003 он гэхэд 1,000MW хөнгөн Умард Солонгос төрөгчийн цөмийн 2 реактор барьж өгөх, төслийг хэрэгжүүлэхийн тулд олон улсын концерн- Солонгосын хойгийн Эрчим Хүчний Хөгжлийн Байгууллага (KEDO-Korean Peninsula Energy Development Organization)-ыг байгуулж, бүрэлдэхүүнд нь АНУ, Япон, ЕХУ орж, гол ивээн тэтгэгч нь Өмнөд Солонгос, Япон улс болсон байна. Мөн жил бүр 500 мянган тн эрчим хүчний зориулалттай түүхий эд нийлүүлэхээр болжээ. Ингэж Солонгосын хойгийн цөмийн эхний хямралыг харилцан буулт

9. Steven Greenhouse, “Christopher Says U.S. Stays Firm on Korea, but Pledges Diplomacy,” New York Times, March 23, 1994.

хийж, яриа хэлэлцээрийн аргаар зохицуулсан байна.

Солонгосын хойгийн цөмийн хоёрдугаар хямрал

АНУ ба Умард Солонгос-ын хооронд байгуулагдсан суурь хэлэлцээр Умард Солонгос-ын цөмийн асуудлыг шийдвэрлэхэд чухал баримт бичиг болсон ч хэрэгжилт нь хангалтгүй байв. Умард Солонгосын цөмийн хөтөлбөрийг царцаах асуудал бүрмөсөн шийдэгдээгүй ба АНУ-ын талаас эхэлсэн цөмийн реактор барих ажил ч зогсонги байдалд орсон юм. 1994 онд БНАСАУ-ын удирдагч Ким Ир Сен нас барсны дараа түүний орыг залгамжлан авсан хүү Ким Жон Ир “цэргийг түрүүнд” тавих бодлогыг гарган тавьж, “империализмтай тэмцэнэ” гэсэн уриа дэвшүүлж, 1998 онд “Тепходон 1” дунд тУмард Солонгосгалын баллистик пуужингийн туршилт хийж, цөмийн хөтөлбөр нууцаар боловсруулж байж болзошгүй мэт байв. 1998 онд АНУ Умард Солонгос-ыг Кым Чанри-д газар дор цөмийн тоноглол байгуулж байж болзошгүй гэж хардаж шалгасан ч тогтоож чадаагүй юм. 1999 оны 5 сард У.Перри Пхеньянд айлчилсныхаа дараа АНУ-ын Умард Солонгос-ын цөмийн асуудалд баримтлах стратегийг энх тайвнаар зэрэгцэн орших эсвэл тогтоон барих гэсэн 2 чиглэлтэй байхыг тодорхойлжээ.

2001 онд Бушийн Засгийн Газар гарч ирснээр энх тайвныг “хүчээр” хангах гэсэн реалист гадаад бодлогыг илэрхийлэх болов.¹⁰ Б.Клинтоны Умард Солонгос-ын талаар баримтлах болсон “хөнгөн газардуулах” (soft landing) бодлого Бүгд Найрамдахчуудын шүүмжлэлд өртөв. Умард Солонгос-ын талаарх Клинтон бодлогыг бүрэн шинжилж, дүгнэсний дараа 2001 оны 6 сарын 6-нд Буш-ийн ЗГ Умард Солонгос-ын эсрэг хориг арга хэмжээг дараах нөхцөлд: ӨС-т ердийн зэвсгийн аюулыг бууруулахын тулд шийдвэртэй алхам хийж эхлэх, 1994 оны суурь гэрээний “гүйцэтгэлийг сайжруулах”, Умард Солонгос пуужингийн экспортыг хязгаарлах шалгалт хийх боломжоор хангах тохиолдолд сулруулж болох тухай саналтайгаа мэдэгджээ.¹¹

10. 김성환, “부시 행정부 출범이후 미국의 동북아 전략과 대북정책”, “민주논단”, 2001년 봄호, p.29 /Ким Сон Ха, “Буш-ийн ЗГ гарч ирснээс хойшхи АНУ-ын ЗХА дахь стратеги ба Умард Солонгос-г явуулсан бодлого”, “Ардчилсан хэлэлцүүлэг”, 2001 он. Хаврын дугаар. Тал. 29/).

11. Mark E. Manyin, Emma Chanlett-Avery, and Helene Marchart, “North Korea: A Chronology of Events, October 2002-December 2004,” Congressional Research Service, January 24, 2004, 11

Цөмийн зэвсэг болон алсын тУмард Солонгосгалтай пуужингийн талаар Умард Солонгос-той тохиролцоонд хүрэх зарчмыг бүрэн төгс, шалгалт, цөмийн зэвсгийн эргэлт буцалтгүй Умард Солонгостгах (CVID: Complete, Verifiable, Irreversible Dismantlement) гэж үзэж байв.

Мөн 2001 оны 9 сарын террорист халдлагын дараа АНУ Пуужингийн Эсрэг Үндэсний Батлан Хамгаалах Систем (NDS, National Missile Defense) программыг боловсруулж эхэлсэн ба үүнийгээ Умард Солонгос, Иран г.м. улсын пуужингийн довтолгооноос хамгаалах үр дүнтэй систем гэж үзэж байв. 2002 оны 1 сард Ж. Буш Умард Солонгос-ыг цөмийн зэвсгээр хөөцөлдөж, терроризмыг дэмжигч гэж үзэн “муугийн тэнхлэг”(axis of evil)-ийн жагсаалтанд оруулав.¹²

Умард Солонгос-ын тал ч Бушийн ЗГ-ийн бодлогод дургүйцсэнээ төвийн мэдээллийн хэрэгслүүдээрээ дамжуулан илэрхийлж байв. 2002 оны 8 сарын 13-нд Умард Солонгос гадаад явдлынхаа яамны төлөөлөгчөөрөө дамжуулан АНУ-ын хөнгөн Умард Солонгос төрөгчийн цөмийн реактор барьж өгнө гэсэн амлалтнаасаа буцсан эрчим хүчний алдагдлыг нөхөж өг гэсэн шаардлага тавив.¹³

2002 оны 10 сард АНУ, БНАСАУ-ын дээд хэмжээний уулзалтанд оролцсон АНУ-ын ерөнхийлөгчийн тУмард Солонгосгай элч, ТНБД-ын тУмард Солонгослах Жэймс Келли (James Kelly) Пхеньянд айлчилсныхаа дараа Умард Солонгос-ыг цөмийн зэвсэг хийх нууц төлөвлөгөөтэй байж болохыг мэдэгджээ.¹⁴ БНАСАУ-ын тал ч үүнийг үгүйсгээгүйгээр барахгүй 2002 оны 10 сарын 25-ны өдөр Умард Солонгос-ын ГХЯ-ны төлөөлөгч “Бид АНУ-ын цөмийн шахалт хүндрэх аюулын эсрэг тУмард Солонгосгаар тогтнол, оршин тогтнох эрхээ хамгаалахын тулд мэдээж цөмийн зэвсэг, мөн түүнээс их зүйлтэй байхыг тодорхой харуулж байна” гэж мэдэгджээ. Энэ нь Умард Солонгос цөмийн хөтөлбөр эрчимтэй хэрэгжүүлж байж болзошгүй гэсэн таамгийг улам лавшруулсан юм.

Хатуу байр суурийг баримтлах болсон АНУ-ын ЗГ 2002 оны 11 сард явагдсан Солонгосын Хойгийн Эрчим Хүчний Байгууллага

12. The President's State of the Union Address. 2002, January 29. <http://www.whitehouse.gov/news/>

13. 2002. 8 월 18일 노동신문. Нодун сонин. 2002.08.18

14. 양무진, “제2차 북핵문제의 미북 간 대응전략”, /현대북한 연구/ 2007. pp.86 Ян Му Жин, “2 дахь удаагийн Умард Солонгосын цөмийн асуудал ба АНУ-Умард Солонгосын эсрэг тэсрэг стратеги”, “Орчин үеийн Умард Солонгосын судалгаа”, 2007, тал.86)

(KEDO)-ийн хуралдаан дээр мөн оны 12-р сараас Умард Солонгос-т эрчим хүчний зориулалттай түүхий эд нийлүүлэхээ зогсоох болсноо шийдвэрлэж, удалгүй ОУАЭА-ийн шалгалт оруулахыг шаардсан тогтоолын төслийг баталжээ.

Харин Умард Солонгос-ын тал 12 сарын 23-аас цөмийн төхөөрөмжөө царцаасан хяналтын камер ба цацрагийн лабораторийнхоо лацыг авч хаяж, 5MW цөмийн төхөөрөмжөө шинээр шатахуунаар хангаж, IAEA шинжээчдийн багийг гаргахаар болж, 2003 оны 1-р сард БНАСАУ-ын нэрийн өмнөөс “БНАСАУ Цөмийн Зэвсэг Үл Дэлгэрүүлэх Тухай Гэрээнээс гарахтай холбогдуулан өөрийгөө шударга, нээлттэй хамгаалах арга хэмжээ” гэсэн мэдэгдэл хийж Цөмийн Зэвсэг Үл Дэлгэрүүлэх Тухай Гэрээнээс гарахаар мэдэгджээ.

Умард Солонгос ЦЗҮДТГ (NPT)-нээс гарахаар мэдэгдсэний дараа Вена-д болсон ОУАЭА (IAEA)- гишүүдийн онц хурлаас Умард Солонгосын цөмийн зэвсгийн асуудлыг 2003 оны 2 сарын 12-ны НҮБ-ын АЗ-ийн Ерөнхий Ассамблейд илтгэх агуулгатай шийдвэр гаргажээ. Ийнхүү Умард Солонгос-ын цөмийн зэвсгийн асуудал хурцадмал байдалд орж, бүс нутаг, цаашилбал дэлхий нийтийн аюулгүй байдалд нөлөөлөх хэмжээнд хүрсэн ба үүнийг солонгосын хойгийн цөмийн хоёрдугаар хямрал гэж нэрийдэх болсон байна. Энэ хямралыг шийдвэрлэхийн тулд АНУ, Умард Солонгос ба тУмард Солонгос бүс нутгийн улс орнууд (БНХАУ, ОХУ, Япон, БНСУ) оролцсон зургаан талт хэлэлцээ (Six Party Negotiation) явагдах үй явц өрнөсөн нь уг хямрал АНУ ба Умард Солонгос гэсэн хоёр гол оролцогчоос хальж ЗХА-ийн бүс нутгийн хэмжээнд хүрч, глобал шинж чанартай болсныг илтгэнэ. 6 талт хэлэлцээгээр олон асуудлаар тохиролцоо оролдлого хийж, солонгосын хойгийн хурцадмал асуудлыг түр намжааж байсан ч бүрэн шийдвэрлэж хараахан чадаагүй юм. Энэ хэлэлцээрийн талаар тУмард Солонгосд нь дэлгэрэнгүй өгүүлэл бичигдсэн болно.

Умард Солонгос-ын цөмийн туршилт

2006 он гарсаар Умард Солонгос хэд хэдэн пуужингийн туршилт явуулж, солонгосын хойгт дахин хурцадмал байдал бий болов. Гадаадын хэвлэлүүдэд Умард Солонгосыг цөмийн зэвсгийн туршилт явуулах гэж байна гэсэн мэдээллүүд гарах болж дэлхийн олон улс

цөмийн зэвсгийн туршилт нь Умард Солонгост таагүй зүйл авчирна гэж сануулж, туршилтаас хэд хоногийн өмнө НҮБ-ын АЗ Умард Солонгосыг цөмийн зэвсгийн туршилт хийхээс татгалзахыг уриалсан тУмард Солонгосгай мэдэгдэл хийжээ. Энэ бүхнийг үл харгалзан БНАСАУ 2006 оны 10 сарын 9-нд цөмийн туршилт амжилттай явуулсныг зарласны дараа мэргэжилтнүүд 0,5 килотонн байсан гэж дүгнэв. Үүний дараа Умард Солонгос 2009 оны 5 сарын 25-нд 10-20 килотонн хүчтэй цөмийн туршилтыг 2 дахь удаагаа, 2013 оны хоёрдугаар сарын 12-нд 3 дахь удаагаа цөмийн туршилт хийснийг АНУ-ын геологийн алба тэмдэглэжээ.

Умард Солонгос цөмийн зэвсгийн туршилт хийх болгонд дэлхий нийт уг үйлдлийг нь буруушааж, НҮБ-ын АЗ-өөс хориг арга хэмжээний тогтоол (№1718, 1874, 2087) гаргаж байв. Уг тогтоолуудад: БНАСАУ-д зэвсэг, цөмийн зэвсэг үйлдвэрлэх материал болон тансаг эд зүйлсийн экспортыг хориглох, тУмард Солонгос улсыг цөмийн зэвсэгтэй улсын тоонд оруулахыг үл зөвшөөрөх, ЦЗҮДТГ (NPT), ОУАЭА (IAEA) аюулгүйн үйл ажиллагааны арга хэмжээнд нэн даруй эргэн оруулах, 6 талт хэлэлцээрт нэн даруй, ямар ч нөхцөлгүй эргэн оруулах мөн цөмийн зэвсгийн туршилтыг бүх талаар хориглосон гэрээнд (CTBT: Comprehensive Nuclear-Test-Ban Treaty) орохыг хатуу шаардах зэрэг асуудлуудыг тУмард Солонгосгаж байв. Уг тогтоолуудыг БНХАУ-ч дэмжиж, нэгдэн орсон ба Умард Солонгос-ын цөмийн зэвсгийн туршилтуудыг Хятад улс тууштай эсэргүүцсэн байр сууриа илэрхийлэх болсон юм. БНХАУ-ын ГХЯ-наас “Хятад улс Умард Солонгос цөмийн зэвсэгтэй байхын эсрэг бөгөөд Хятадын ЗГ Пхеньяны цөмийн хөтөлбөрийн тухайд хатуу байр суурьтай ба тУмард Солонгос улсыг дахин цөмийн туршилт хийхээс сэргийлүүлэх санаатай байна. ...Умард Солонгос олон улсын хамтын эсэргүүцлийг үл тоон дахин цөмийн туршилт хийсэн явдалд БНХАУ-ын ЗГ эрс эсэргүүцэж байна гээд Умард Солонгосыг зэмлэн буруушааж... Хятад улс Солонгосын хойгийн энх тайван тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх, Солонгосын хойгийг цөмийн зэвсэггүйжүүлэх байр суурь тодорхой ба өөрчлөгдөхгүй” гэх зэрэг мэдэгдлүүд гаргаж, Умард Солонгос-ын 2 дахь цөмийн туршилтын дараа БХАДХ-ын орлогч дарга Чен Жы Ли Умард Солонгост хийх айлчлалаа цуцлах хүртэл арга хэмжээ авч байв.¹⁵

15. 한석회, “북한 핵 문제에 대한 중국의 입장: 제2차 북한 핵실험 이후를 중심으로, /Хан Сог Хи, “Умард Солонгос-ын цөмийн асуудлын талаарх Хятадын байр суурь: Умард Солонгос-ын 2 дахь удаагийн цөмийн

Энэ бүхнээс дүгнэлт хийхэд Умард Солонгос-ын цөмийн асуудал солонгос үндэстэн хоорондын сөргөлдөөнөөр үүсч, Умард Солонгос улсаа хамгаалах нэрийн дор дэглэмээ хадгалж үлдэх гол арга замыг цөмийн зэвсэг гэж үзсэнээр солонгосын хойгийн цөмийн хямрал үүсчээ. Умард Солонгос-ын энэхүү бодлогыг зогсоох гэсэн АНУ тэргүүтэй дэлхийн улс түмний хүчин чармайлт БНАСАУ цөмийн зэвсэгтэй болсноор үр дүнд хүрээгүй ажээ. Умард Солонгос цөмийн зэвсэгтэй болсноор эргэн тойрны улс орнуудын аюулгүй байдлыг эрсдэлд оруулж, Умард Солонгос-ын цөмийн зэвсгийн аюул дор ЗХА-ийн улс орнууд, тухайлбал: Өмнөд Солонгос, Япон, Тайван зэрэг орнууд цөмийн зэвсэглэлээр хөөцөлдөж болзошгүй нөхцөлийг үүсгэв. Ингэснээр солонгосын хойгийн цөмийн зэвсэг үндэстний асуудлаас хальж бүс нутгийн, цаашилбал глобал шинж чанартай болжээ. БНАСАУ-ын цөмийн зэвсгээр хөөцөлдөх бодлого өөрийгөө хамгаалах бУмард Солонгос үндэстэн хоорондын сөргөлдөөнийг улам хурцатгаж, харилцан зэвсэглэлээр хөөцөлдөхөд хүргэж, бүс нутгийн бУмард Солонгосад орон түүний дотор МУ-ын аюулгүй байдлыг ч эрсдэлд оруулж байна гэж дүгнэхэд хүргэж байна. Умард Солонгосын цөмийн хөтөлбөр бүс нутаг хийгээд Ази тивийн аюулгүй байдалд хэрхэн нөлөөлөх талаархи дүгнэлтийг Х.Киссенжер дараах байдлаар өгчээ. “Хойд Солонгосын цөмийн хөтөлбөрийн эхний 10 жилд уг асуудал нь зөвхөн АНУ ба Хойд Солонгосын хооронд шийдэгдэх ёстой гэсэн байр суурийг Хятад баримталж байв. Хойд Солонгос нь юуны өмнө АНУ-ын заналд өртөж буй гэж үзэж байгаатай холбогдуулан түүнд цөмийн зэвсгийг орлуулах аюулгүй байдлын баталгааны тухай ойлголт өгөх нь АНУ-ын хэрэг гэж Хятад тооцож байв. Гэвч цаг хугацаа одох тУмард Солонгосам Хойд Солонгост цөмийн зэвсэг эзэмшихийг зөвшөөрөх нь эрт, хожид хэзээ нэгэн цагт Хятадын аюулгүй байдалд нөлөөлөх нь илт болов. Хэрэвзээ Хойд Солонгос нь цөмийн гүрний тоонд орвол Япон, Өмнөд Солонгос, мөн магадгүй Вьетнам, Индонези зэрэг Азийн зарим орнууд цөмийн зэвсэгтний клубт нэгдэх өндөр магадлалтай болж Азийн стратегийн орчин өөрчлөгдөх юм” гэжээ.¹⁶

туршилтын дараа/ EAI Issue Briefing, 2009년 7월, p.1.”

16. Хенри Киссинжер. Хятад. Монгол орчуулга. 2014. II дэвтэр. Тал: 635

Умард Солонгос-ын цөмийн зэвсгийн талаарх Монгол Улсын байр суурь

Монгол улс бүс нутгийн аюулгүй байдлыг тогтвортой байлгах, цөмийн зэвсгийг дэлгэрүүлэхгүй байхад ямагт санаа тавьж, энэ талын олон улсын санаачлагыг үргэлж дэмжиж ирсэн. Үүний баталгаа нь МУ 1969 онд ЦЗҮДГ (NPT)-нд нэгдэн орж, 1973 онд ОУАЭА-ийн гишүүн болж, 1992 онд нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй БУмард Солонгос нутаг гэж дангаараа зарлаж, 2000 оны 2-р сард Цөмийн Зэвсгээс ангид байх тухай хууль батлан гаргасан зэргийг дурьдаж болохоор байна.

Дээр дурьдсанчлан солонгосын хойгийн цөмийн хямрал бүс нутгийн, глобал шинж чанартай болсон, мөн манай хөрш улсууд-Хятад, ОХУ ба гуравдагч хөрш- АНУ, Япон, Өмнөд Солонгос зэрэг улс орнуудын эрх ашигтай шууд холбогдсон зэрэг нь МУ-ыг уг асуудлын гадна үлдэх ямар ч боломжгүй болгож байна гэж үзэх үндэстэй. Энэ ч утгаараа МУ солонгосын хойгт цөмийн хямрал үүссэн цагаас нь эхэлж өөрийн байр суурийг тодорхой илэрхийлж, уг асуудлыг шийдвэрлэхэд багагүй хүчин чармайлт гаргаж ирсэн.

1993 онд солонгосын хойгийн цөмийн нэгдүгээр хямрал буюу Умард Солонгос ЦЗҮДТГ (NPT)-ээс гарах тухайгаа мэдэгдсэний дараа Монгол улс Умард Солонгос-ын энэхүү үйлдлийг БУмард Солонгосад улсын нэгэн адилаар буруушааж, МУ-ын ГХЯ-аас доорх агуулгатай мэдэгдлийг гаргажээ. Үүнд:

Сүүлийн үед Солонгосын хойгт сөргөлдөөнт байдал даамжирч, БНАСАУ “Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх тухай гэрээ”-нээс гарна гэж мэдэгдсэнд монголын тал гүнээ харамсаж сэтгэл түгшиж байна. Олон улсын харилцааны аливаа маргаантай асуудал, ээдрээтэй байдлыг эв зүй, яриа хэлэлцээний замаар шийдвэрлэх нь холбогдох талууд, улмаар бүс нутгийн хийгээд дэлхийн улс түмний эрх ашигт бүрэн нийцэхсэн билээ. Монгол улс цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх тухай гэрээ, түүний дэг журмыг бэхжүүлэхийн төлөө аливаа чармайлтыг ямагт дэмжиж ирсэн бөгөөд цаашид ч чингэх болно. 1993 оны гуравдугаар сарын 13.¹⁷

Мөн энэхүү үйл явдал буюу БНАСАУ “ Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх тухай гэрээ”-нээс гарахаар төлөвлөж байгаатай

17. Үнэн сонин. 1993.3.13 № 42(542)

холбогдуулан гэрээ хадгалагч орнууд буюу ОХУ, Нэгдсэн Вант улс, АНУ-ын ЗГ-ууд хамтарсан мэдэгдэл хийсэнтэй холбогдуулан 1993 оны 4-р сарын 13-нд МУ-ын ГХЯ-ны төлөөлөгчийн мэдэгдэл гаргаж, үүндээ МУ Гэрээнд оролцогч орны хувьд дэмжиж, түүнд нэгдэж байгаагаа илэрхийлсэн байна.¹⁸

Харин БНАСАУ-ын тал МУ-ын энэхүү мэдэгдлүүдэд ихээхэн тааламжгүй ханджээ. БНАСАУ-ын ГЯЯ-ны II газрын дарга Чан Гван Сон 1993 оны 5-р сарын 12-нд МУ-аас тУмард Солонгос улсад сууж байсан элчин сайд Ш.Гунгаадоржийг урин уулзаж: ... Монгол улс манай эсрэг, АНУ-тай нэг адил байр суурьтай байна. 3 сарын 13-ны мэдэгдлийг энэ асуудлын нарийн учрыг сайн ойлгоогүй яарч гаргажээ гэж үзсэн...Гэтэл 4 сарын 13-ны мэдэгдэлдээ АНУ, ОХУ, Английг дэмжиж байна гээд тэдэнтэй хамтран ажиллана гэж байр сууриа илэрхийлжээ. Уламжлалт харилцаатай Монгол улс ингэснээрээ манайд найрсаг бУмард Солонгос хандлаа. Биднээс урваж, Азийн энх тайван, хойгийн нэгдлийн төлөө манай ард түмний тэмцэл рүү Умард Солонгос цацлаа... Танай энэ хандлага хоёр талын харилцаанд муугаар нөлөөлнө. Үүний хариуцлагыг Монголын тал хүлээх болно. Өмнөд Солонгост гадаадын цэрэг, цөмийн зэвсэг байна. Тим спирт цэргийн хээрийн сургууль явуулж байна. Энэ талаар огт дуугараагүй. Цөмийн асуудал нь угтаа АНУ ба Гуравдахь ертөнцийн хоорондын тэмцлийн асуудал. Монголын тал цаашид ийм байдлаар хандвал бид танай эсрэг хариу арга хэмжээ авна. Та нарт гашуун амтагдах болно шүү. Энэ талаар ЗГ-таа мэдэгдэж, манай цөмийн асуудалд анхааралтай хандахыг хүсье гэжээ. Харин бичгээр илэрхийлэхийг хүсэхэд бидний дараагийн арга хэмжээ бичгээр албан ёсоор илэрхийлэхээс ч илүү ноцтой байх болно гэж хүртэл мэдэгдсэн байна.¹⁹

Энэ үеэс Умард Солонгосын тал манай улсад нэлээд тааламжгүй хандах болсон ба 2000 оны эхэн үе хүртэл харилцаагаа ч нэлээд хүйтрүүлжээ. Дурьдсан хугацаанд буюу 2002 он (2002 оны 8 сард БНАСАУ-ын ГХ-ийн сайд Пэк Нам Сун-ы айлчлал) хүртэл БНАСАУ-ын Монголд хийсэн дээд хэмжээний айлчлал зөвхөн дэд сайдын хэмжээнд хийгдсэн нь харагддаг. Энэ нь солонгосын хойгийн хямралын эхэн үед

18. Мөн тэнд. 1993.4.16. №60(560)

19. ГХЯ-ны архив. Хн:191, тал.191

хоёр орны харилцаа шинэ шатанд шилжсэнтэй холбоотой хараахан бүрэн тодорхойлогдоогүй байсантай холбоотой гэж үзэж болох юм.

Харин Солонгосын хойгийн хоёрдугаар хямралын үеэс Умард Солонгос-ын цөмийн асуудалтай холбоотой Монголын байр суурь нэлээд тодорхой болж эхэлсэн юм. Энэ үеэс Монгол улс уг асуудалд анхаарлаа илүү хандуулж, оролцоогоо нэмэгдүүлэх, солонгосын хойгийн цөмийн зэвсгийн асуудлыг эв зүйгээр шийдвэрлэхэд илүү хүчин чармайлт гаргах хэрэгтэй гэж үзэх болсон. Монгол улс БНАСАУ-тай уламжлалт сайн харилцаатай орны хувьд тУмард Солонгос орныг ганцаардуулахгүй байх, тУмард Солонгос оронтой тогтоосон харилцаагаа хадгалж үлдэх, мөн тУмард Солонгос орны байр суурь ба бУмард Солонгосад орны байр суурийг харилцан ойлгуулахад зуучлах зэрэг олон талын үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна. Солонгосын хойгийн цөмийн асуудал хурцадсан яг тэр үед, тухайлбал 2003 оны 1 сард Монгол улсын ГХ-ийн сайд Л.Эрдэнэчулуун БНАСАУ-д айлчилж, тулгамдсан олон асуудлаар БНАСАУ-ын байр суурийг төр засгийн удирдах хүмүүсээс нь тодруулж, маргаантай асуудлыг яриа хэлэлцээний аргаар, энх тайвнаар шийдвэрлэх тухай Монгол улсын ЗГ-ийн байр суурийг илэрхийлж, санал солилцож, мөн тУмард Солонгос улсын байр суурь, байдлыг бУмард Солонгосад оронд бодитойгоор ойлгуулах боломжтойгоо илэрхийлсэн юм. Монгол улсын ГХ-ийн сайд Л.Эрдэнэчулууны айлчлалын үеэр Умард Солонгос-ын тал АНУ-д дараах 4 зүйлийг уламжилж өгөхийг хүссэн байна. 1. Умард Солонгос-ын эсрэг дайсагнасан бодлогоосоо татгалзах, 2. Умард Солонгос АНУ-ын хооронд үл довтолж хэлэлцээ байгуулах, 3. Умард Солонгос эдийн засгийн хөгжилд саад тотгор үзүүлэх бодлогоосоо татгалзах, 4. Хэрэв АНУ-ын талаас шахалт, дарамт учруулсаар байх аваас Умард Солонгос тал хариу ямар ч алхам хийхэд бэлэн байна. Энэхүү айлчлал нь Солонгосын хойгийн асуудал хурцадсанаас хойш Умард Солонгос-д ГХ-ийн сайдын төвшинд гадаад орнуудаас хийгдсэн анхны айлчлал болсноороо ихээхэн чухал ач холбогдотой байсан төдийгүй Монгол улс солонгосын хойгийн цөмийн хямралын асуудлыг зохицуулахад тодорхой байр суурьтай оролцож болохыг нотолсон ажээ.²⁰

20. ГХЯ-ны архив. Хн: 219. Тал. 36

Үүний дараа 2003 оны 1-р сарын 24-нд Давост болсон дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтын үер Монгол улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр АНУ-ын ТНБДК.Пауэлтэй уулзах үеэр Солонгосын цөмийн асуудлыг хөндөн ярьж, БНАСАУ-ын байр суурийг тайлбарлан санал солилцсон бөгөөд уулзалтын үр дүнгийн талаар Умард Солонгосын талд албан ёсоор мэдээлж, Монгол улс цаашид ч Умард Солонгосын цөмийн асуудлыг яриа хэлэлцээний аргаар шийдвэрлэхэд тУмард Солонгос дөхөм үзүүлэхэд бэлэн байгаагаа илэрхийлсэн байна.²¹

Мөн МУ солонгосын хойгийн хоёрдугаар хямралын үеэр АНУ Умард Солонгост мазут нийлүүлэхээ зогсоосныг шүүмжилсэн нь бас онцлого байсан ба энэхүү Монголын байр суурийг БНСУ, Японы тал ч ойлгон хүлээн авсан байна. 2003 оны 4 сарын 24-нд Монгол улсын ГХЯ-аас Солонгосын Хойгийн хямралыг зохицуулахын төлөө яриа хэлэлцээ сэргэж байгаад талархаж байгаагаа илэрхийлсэн мэдэгдэл гаргажээ.²²

Монгол улс Умард Солонгос-ыг цөмийн зэвсгээр хөөцөлдөхгүй байхыг уриалж, энэ нь бүс нутгийн аюулгүй байдалд сэргөөр нөлөөлөхийг сануулж байв. Монгол улс энэхүү байр сууриа Умард Солонгос-ын удаа дараагийн цөмийн туршилтын үеэр ГХЯ-аараа дамжуулан гаргасан мэдэгдэлдээ тодорхой тУмард Солонгосгаж байв. Умард Солонгос-ын цөмийн туршилт хийсэнтэй холбогдуулан гаргасан МУ-ын ГХЯ-ы мэдэгдлүүд:

Умард Солонгос-ын цөмийн нэгдүгээр туршилт хийсэнтэй холбогдуулж гаргасан 2006 оны 10 сарын 9-ны мэдэгдэл:

БНАСАУ дэлхийн хамтын нийгэмлэгийн хүсэл, шаардлагыг үл харгалзан цөмийн туршилт хийсэнд МУ гүнээ харамсаж байна. БНАСАУ-ын энэ үйлдэл нь цөмийн зэвсгээр хөөцөлдөх аюулыг даамжруулах, ЗХА-д хямралт байдал бий болгох ноцтой үр дагаварт хүргэж болзошгүй гэж МУ үзэж, асуудалд холбогдох талууд хүлээцтэй хандаж, яриа хэлэлцээрийн замаар шийдвэрлэхэд чиглэсэн чармайлт гаргахыг уриалж байна. ГХЯ-ны Азийн Газар. 2006.10.09²³

21. ГХЯ-ны архив. Хн: 234. Тал.173/

22. мөн тэнд. Хн: 234, тал. 31/

23. мөн тэнд. Хн: 241, тал 137/

Умард Солонгос-ын цөмийн хоёрдугаар туршилт хийсэнтэй холбогдуулан гаргасан 2009 оны 5 сарын 27-ны мэдэгдэл: БНАСАУ НҮБ-ын АЗ-ийн 1718 тоот тогтоолыг зөрчин, дэлхийн хамтын нийгэмлэгийн зүй ёсны болгоомжлол, хүсэл эрмэлзлэлийг үл харгалзаж, энэ сарын 25-нд цөмийн туршилт дахин хийсэнд ЗХА-ийн бүс нутагт хаяа хатган оршдог орны хувьд МУ гүнээ харамсаж байна. БНАСАУ ийнхүү цөмийн туршилт хийсэн нь бүс нутагт зэвсэглэлээр хөөцөлдөх сэтгэхүйг хөөргөх ноцтой эрсдэл дагуулж болзошгүй юм. МУ цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх, цөмийн зэвсэггүй Солонгосын хойгийн төлөө уламжлалт байр сууриа нотлон Умард Солонгосын цөмийн асуудлыг дипломат арга хэрэгслээр шийдвэрлэхийн төлөө байдгийг дахин мэдэгдэхийн зэрэгцээ бүс нутгийн болон олон улсын харилцааг цаашид аливаа алхам хийхгүй байхыг БНАСАУ-д уриалж байна.²⁴

Умард Солонгос-ын цөмийн гуравдугаар туршилт хийсэнтэй холбогдуулан гаргасан 2013 оны 2 сарын 15-ны мэдэгдэл: БНАСАУ олон улсын хамтын нийгэмлэгийн болгоомжлол, анхааруулгыг үл харгалзан НҮБ-ын АЗ-ийн холбогдох тогтоолуудыг зөрчин газар доорхи цөмийн туршилт хийсэнд МУ гүнээ харамсаж байна. БНАСАУ-ын энэхүү алхам нь ЗХА-ийн бүс нутгийн төдийгүй олон улсын энх тайван, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх ноцтой үр дагавартай юм. МУ нь Солонгосын хойгийг цөмийн зэвсгээс ангид байлгахын төлөө уламжлалт байр сууриа нотлон, Умард Солонгосын цөмийн асуудлыг дипломат арга замаар шийдвэрлэх ёстойг мэдэгдэхийн зэрэгцээ хурцадмал байдлыг цаашид дэвэргэх аливаа алхам хийхгүй байх, асуудалд хүлээцтэй хандахыг холбогдогч бүх талуудад уриалж байна гэжээ.²⁵

Эдгээр мэдэгдлүүдээс дүгнэхэд МУ-ын солонгосын цөмийн зэвсгийн талаар баримталсан байр суурийг дараах байдлаар тодорхойлж болохоор байна.

1. Умард Солонгос-ын цөмийн зэвсгээр хөөцөлдөх бодлогын эсрэг,
2. Солонгосын хойгийг цөмийн зэвсгээс ангид байлгах,
3. Умард Солонгос-ын цөмийн асуудлыг дипломат арга замаар

шийдвэрлэх гэсэн байр суурийг илэрхийлжээ.

24. Зууны мэдээ. 2009.5.27 №121/3193/

25. Зууны мэдээ. 2013.2.15 №37/4352/

Үүнтэй хамт Монгол улс солонгосын хойгийн цөмийн асуудлыг шийдвэрлэхэд харилцан ойлголцол чухлыг байнга сануулж ирсэн ба БНАСАУ-тай уламжлалт сайн харилцаатай орны хувьд тУмард Солонгос улсыг хэт ганцаардуулахгүй байх, Умард Солонгос-ын цөмийн асуудалд төвийг сахих байр суурь баримтлах болжээ.

Тухайлбал: Куала Лумпурт болсон АСЕАНА-ийн уулзалт дээр Умард Солонгосын пуужин харвасан асуудлын талаар Япон, АНУ, Өмнөд Солонгос НҮБ-ийн тогтоолыг даган мөрдөх ёстой гэж шаардсан. Харин Австрали, Монгол энэ асуудлаар харамслаа илэрхийлж, 6 талт уулзалтыг сэргээх нь зүйтэй гэсэн байр суурь илэрхийлжээ.²⁶

2007 оны 11 сард НҮБ-ын ЕА 62-р чуулганы 3-р бүгд хурлаас ЕХУ ба Японы өргөн барьсан “БНАСАУ дахь хүний эрхийн байдлын тухай тогтоол”-ыг батлах санал хураалт явуулахад Хятад тэргүүтэй 23 улс эсэргүүцэж, 97 улс зөвшөөрч, Өмнөд Солонгос тэргүүтэй 60 улс санал хураалт өгөхөөс тагазлзсаны нэг нь МУ байсан²⁷

МУ-ын ГХЯ-наас Умард Солонгосыг терроризмыг дэмжигч орны жагсаалтаас хасах болсонтой нь холбогдуулан баяр хүргэсэн мэдэгдэлд: АНУ ЗГ БНАСАУ-ыг “терроризмыг дэмжигч улсуудын” жагсаалтаас хасах шийдвэр гаргаж, БНАСАУ Ёнбин дэх цөмийн байгууламжуудаа сэргээх ажлыг зогсоохоор шийдвэрлэсэнд МУ-ын ГХЯ баяр хүргэж байна. Энэхүү үйл явдал нь солонгосын хойгийг цөмийн зэвсгээс ангижруулах, бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг хангах, харилцан ойлголцлыг бэхжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулах нэг алхам гэж итгэж байна гэжээ. 2008.10.11²⁸

МУ хэдийгээр 6 талт хэлэлцээнд орох боломжоор хангагдаж чадаагүй ч 6 талт хэлэлцээний хоёр талын харилцааг хэвийн болгох уулзалтыг Улаанбаатарт зохион байгуулах талаар уйгагүй санаачлага гаргасны үр дүнд Умард Солонгос, Японы ажлын хэсгийн уулзалтыг 2008, 2012 онд УБ-т хүлээн авч зохион байгуулсан. Мөн 2013 оны 4-р сард УБ хотноо зохиогдсон Ардчилсан Орнуудын Хамтын Нийгэмлэгийн Сайд нарын 7-р хурлын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “Хельсинкийн үйл явц”-ыг жишээлэн “Зүүн Хойд Азийн

26. ГХЯ-ны архив. Хн: 242. тал.20

27. мөн тэнд. Хн:255.тал.45

28. мөн тэнд. Хн:256.тал. 34

Аюулгүй байдлын асуудлаарх Улаанбаатарын яриа хэлэлцээ”-г бий болгоё гэдгээ илэрхийлсэн. Гол асуудал нь Умард Солонгос-ын цөмийн зэвсэг бөгөөд уг санаачилгын олон улсын бага хурал жил бүр манай улсад зохигдох болжээ. Энэхүү санаачлага нь БНСУ-ын ерөнхийлөгч Пак Гён Хи-ийн дэвшүүлсэн итгэлцлийн бодлого буюу “ЗХА-ийн энх тайван ба хамтын ажиллагааны санаачлага”²⁹-тай нэг талаараа адил ба хоёр солонгостой сайн харилцаатай Монголын хувьд илүү боломжийг олгож байж болох юм.

ДҮГНЭЛТ

Ийнхүү Монгол улс Умард Солонгос-ын цөмийн зэвсгээр хөөцөлдөх бодлогыг анхнаас нь буруушааж, энэ нь ЗХА-ийн бүс нутгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхийг сануулж, асуудлыг яриа хэлэлцээний замаар шийдвэрлэх байр суурьтайгаа илэрхийлж байсан байна. Солонгосын хойгийн нэгдүгээр хямралын үеэр хоёр орны шинэ харилцааны хандлага хараахан тогтоогүй байснаас үл ойлголцол үүсч байсан ч хоёрдугаар хямралын үеэс Монгол улсын байр суурь тодорхой болж, Монгол улс илүү идэвх санаачлагатай, аль нэг талыг баримтлахгүй, төвийг сахих байр суурьтай болсноор хоёр орны харилцаа ч хэвийн болж тогтжээ. Ингэснээр Монгол улс солонгосын хойгийн цөмийн асуудлыг зохицуулахад холбогдох талуудын байр суурийг бие биед нь ойлгуулах, зуучлагчийн байр суурьтай оролцох, холбогдох талуудын хоёр талын уулзалтыг Улаанбаатарт зохиох болсон байна. Мөн Монгол улс нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй бУмард Солонгос нутаг гэж зарлаж, уг статУмард Солонгосаа НҮБ-ын АЗ-ийн Байнгын таван гишүүн орноор баталгаа гаргуулсан явдал болон Монгол улсын ерөнхийлөгчийн Улаанбаатарын санаачлага ч тэр ЗХА-ийн бүс нутагт цөмийн зэвсгийг дэлгэрүүлэхгүй байх, солонгосын хойгийг цөмийн зэвсгээс ангижруулахад үлгэрлэхүйц, чухал санаачлага болжээ. Цаашид Монгол улс солонгосын хойгийн цөмийн асуудалд баримталж ирсэн бодлогоо тууштай үргэлжлүүлж, БНАСАУ-тай харилцаагаа хэвийн хадгалж, УБ-ын яриа хэлэлцээрийг бодит болгох, түүнчлэн 6 талт хэлэлцээрт оролцох боломжийг түлхүү эрэлхийлэх нь Монгол улсын ЗХА-ийн бүс нутагт эзлэх байр суурийг улам нэмэгдүүлснээр манай орны гадаад бодлогын ололт болно гэж үзэж байна.

29. North East Asia Peace and Cooperation Initiative (NAPCI).

НОМ ЗҮЙ

1. 북한의 외교정책과 대외관계. 김계동. /Умард Солонгос-ын гадаад бодлого ба гадаад харилцаа. Ким Гие Дун/ 2012. pp.247
2. 양무진, “제2차 북핵문제와 미북 간 대응전략”, /현대북한 연구/ 2007. pp.86 Ян Му Жин, “2 дахь удаагийн Умард Солонгосын цөмийн асуудал ба АНУ-Умард Солонгосын эсрэг тэсрэг стратеги”, “Орчин үеийн Умард Солонгосын судалгаа”, 2007, тал.86)
3. Корейский полуостров: метаморфозы послевоенной истории. 2008. Торкунов.А.В., Денисов.в., Ли Владимир, стр.424
4. Б.Лхагваа. Нэгдсэн Солонгос айсуу. Стратегийн судалгааны хүрээлэн. 2015. Тал.132.
5. Хенри Киссинжер. Хятад. Монгол орчуулга. 2014. II дэвтэр. Тал: 635
6. Bazhanov E. Military-Strategic Aspects of the North Korean Nuclear Program. // The North Korean Nuclear Program: Security, Strategy, and New Perspectives from Russia. New York : Routledge, 2000. P. 102.
7. Ж.Батгөр. Зүүн Хойд Азийн бүс нутаг дахь Монгол улсын байр суурь.Олон улсын харилцаа. 2015№1/30(436).
8. Ж. Баясах. Гадаад бодлого хийгээд аюулгүй байдал /түүвэр зохиол/, УБ 2010, Mongolia’s view on the security of the Korean Peninsula, pp. 56-60
9. Kent E. Calder, The North Korean nuclear crisis and American policy. Asia-Pacific Policy Papers Series №1, The Paul H. Nitze School of Advanced International Studies John Hopkins University, 2005.
10. Володин Д. А. США и Северная Корея: от Буша-страшего к Бушу-младшему // США-Канада: экономика, политика, культура. 2003, № 3. с. 37
11. Steven Greenhouse, “Christopher Says U.S. Stays Firm on Korea, but Pledges Diplomacy,” New York Times, March 23, 1994.
12. 김성한, “부시 행정부 출범이후 미국의 동북아 전략과 대북정책”, “민주논단”, 2001년 봄호, p.29 /Ким Сон Хан, “Буш-ийн

- ЗГ гарч ирснээс хойшхи АНУ-ын ЗХА дахь стратегеги ба Умард Солонгос-т явуулсан бодлого”, “Ардчилсан хэлэлцүүлэг”, 2001 он. Хаврын дугаар. Тал. 29.
13. 한석회, “북한 핵 문제에 대한 중국의 입장: 제2차 북한 핵 실험 이후를 중심으로, /Хан Сог Хи, “Умард Солонгос-ын цөмийн асуудлын талаарх Хятадын байр суурь: Умард Солонгос-ын 2 дахь удаагийн цөмийн туршилтын дараа/ EAI Issue Briefing, 2009년 7월, p.1.”
 14. Mark E. Manyin, Emma Chanlett-Avery, and Helene Marchart, “North Korea: A Chronology of Events, October 2002-December 2004,” Congressional Research Service, January 24, 2004, 11
 15. The National Institute for Defence Studies Japan, East Asian Strategic Review 2015, The Korean Peninsula: A Consolidated Kim Jong Un Dictatorship and South Korea’s Delicate Diplomatic Wobbling between the United States and China.
 16. David M. Mrosek. CHINA AND NORTH KOREA: A PECULIAR RELATIONSHIP. March 2011. MONTEREY, CALIFORNIA
 17. Ёсинори Такэда. Северокорейский ядерный кризис и международные отношения в Северо-восточной Азии. Полемика 1. 2005.02.01, ЯДЕРНЫЙ КОНТРОЛЬ № 1 (75), Том 11
 18. The President’s State of the Union Address. 2002, January 29. <http://www.whitehouse.gov/news/>
 19. David L. Caprara, Katharine H.S. Moon and Paul Park, “Mongolia: Potential Mediator between the Koreas and Proponent of Peace in Northeast Asia”, <http://www.brookings.edu/research/opinions/2015/01/20-mongolia-north-korea-caprara-moon-park>
 20. БНАСАУ-ын Үндсэн хууль. 1992,
 21. 2002. 8 월 18일 노동신문. Нодун сонин. 2002.08.18
 22. Үнэн сонин. 1993.3.13 № 42(542)
 23. ГХЯ-ны архив. Хн:191, тал.191
 24. Зууны мэдээ сонин. 2013.2.15 №37/4352/
 25. ДЬЯЧКОВ Илья Владимирович Эволюция северокорейской

ядерной программы в контексте ядерного нераспространения в Северо-Восточной Азии (2-я половина XX – начало XXI вв.) Диссертация на соискание учёной степени кандидата исторических наук. Москва 2014

26. Распутная, Лариса Ивановна . Корейский ядерный кризис: причины, факторы и возможные пути его разрешения. Диссертация на соискание учёной степени кандидата исторических наук. 2008
27. Мирзаян, Геворг Валерьевич. Внешняя политика США и северокорейский ядерный кризис тема. Диссертация на соискание учёной степени кандидата исторических наук. Москва 2008